Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар

## 2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | - | - | - | - | | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанд "Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц”-ийг хэлэлцүүлж Засгийн газрын "Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц батлах тухай" 2024 оны 227 дугаар тогтоолоор батлагдсан. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц батлагдснаар 1.Үр дүнд суурилсан боловсрол, сургалтын тогтолцоог бэхжүүлэн хөгжүүлэх | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боломжтой болж; 2. Иргэд тасралтгүй хөгжих, мэргэжлийн ур чадвар, чадамжаа хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлд идэвхгүй ажил мэргэжил, ур чадвар эзэмших эрсдэлээс урьдчилан сэргийлэхээс гадна суралцагчид кредитээ хөрвүүлэх, дараагийн түвшин дэвшин суралцах боломж нэмэгдэнэ; мөн 3. Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, чадамж ажил олгогчдын хэрэгцээнд илүү нийцэж, бизнесийн өсөлтөд эерэг өөрчлөлт гарч; 4. Иргэд албан боловсролоос гадна албан бус боловсролын болон ажил, амьдралын орчинд сурч, мэдсэн мэдлэг, ур чадвар, чадамжаа хүлээн зөвшөөрүүлнэ, ингэснээр иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж, хөдөлмөрийн үнэлэмж дээшилж; 5. Боловсрол, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын зах зээл болон хөдөлмөрийн зэх зээлийн нийц, уялдаа сайжирч, салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагааны суурь бий болохын зэрэгцээ 6. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц нь боловсрол, сургалтын байгууллагын чанарын баталгаажуулалтын чиглүүлэгч болж, олон улсын болон бүсийн түвшинд үндэсний мэргэжил, диплом, гэрчилгээг хүлээн зөвшөөрүүлэх зэрэг боломж бүрдэх ач холбогдолтой.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.1.1 | Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ. | - | Засгийн газрын тогтоол | Судалгаа | Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарсан байна. | - | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар "Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц”-ийг батлах тухай" асуудлыг хэлэлцэн, баталсан. Монгол Улс өөрийн гэсэн мэргэшлийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үндэсний шаталсан бүтэцтэй болсноор дараах үр дүнд хүрэх боломжтой. Тухайлбал: 1. Үр дүнд суурилсан боловсрол, сургалтын тогтолцоог бэхжүүлэн хөгжүүлэх боломжтой болж; 2. Иргэд тасралтгүй хөгжих, мэргэжлийн ур чадвар, чадамжаа хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлд идэвхгүй ажил мэргэжил, ур чадвар эзэмших эрсдэлээс урьдчилан сэргийлэхээс гадна суралцагчид кредитээ хөрвүүлэх, дараагийн түвшин дэвшин суралцах боломж нэмэгдэнэ; 3. Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, чадамж ажил олгогчдын хэрэгцээнд илүү нийцэж, бизнесийн өсөлтөд эерэг өөрчлөлт гарч; 4. Иргэд албан боловсролоос гадна албан бус боловсролын болон ажил, амьдралын орчинд сурч, мэдсэн мэдлэг, ур чадвар, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чадамжаа хүлээн зөвшөөрүүлнэ, ингэснээр иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж, хөдөлмөрийн үнэлэмж дээшилж; 5. Боловсрол, сургалтын зах зээл болон хөдөлмөрийн зэх зээлийн нийц, уялдаа сайжирч, салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагааны суурь бий болох 6. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц нь боловсрол, сургалтын байгууллагын чанарын баталгаажуулалтын чиглүүлэгч болж, олон улсын болон бүсийн түвшинд үндэсний мэргэжил, диплом, гэрчилгээг хүлээн зөвшөөрүүлэх зэрэг боломжийг олгох юм. 2024.05.30-ны байдлаар тогтоолын төсөл албажиж ирээгүй байгаа болно. Хавсралт: 3 файл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2 | Хос хэлний талаар баримтлах бодлогын чиглэл батлуулна. | - | Бодлогын чиглэл | Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн судалгаа, хос хэлний сургалтын арга зүй | Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлагдсан байна | - | Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сард баталсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль /СӨБЕБТХ/-ийн 7.3-д “Энэ хуулийн 7.2-т заасан суралцагч Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу хос хэлний хөтөлбөрөөр хичээллэх бөгөөд хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн зохицуулалт шинээр нэмэгдсэн. Иймээс тус чиглэлийг батлах биш харин хос хэлний хөтөлбөр батлах зохицуулалттай болсон. Хос хэлний хөтөлбөр батлах болсонтой холбогдуулан "Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төсөл"-д хос хэлний | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын талаар баримтлах чиглэлийг тусгалаа. "Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төсөл"-ийг Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, баталлаа. Тус үзэл баримтлалын "Гурав.Сургалтын хөтөлбөр, түүний бүтэц,боловсруулахад тавих шаардлага" хэсэгт "Хос хэлний сургалт: Өөр хэл бүхий үндэстний цөөнхийн болон олон соёлт гэр бүлтэй суралцагчийн сургалтыг агуулга болон хэлийг интеграцчилан заах арга зүй (АХИС)-г баримталж зохион байгуулна" гэж тусгаж баталсан. Мөн хос хэлний боловсрол гэж хоёр буюу түүнээс дээш хэлээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсролын нэг төрөл хэмээн тодорхойлж өгсөн. Хавсралт: 1 файл | | |
| 1.1.3 | “Насан туршдаа суралцахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай” асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ. | - | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн хуралдааны 22 дугаар хурлын тэмдэглэл | Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарсан байна. | - | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар “Гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг хэлэлцэж, 222 дугаар тогтоолоор баталсан. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох яамдаас санал авах явцад Сангийн яамны саналыг үндэслэн тогтоолын төслөөс "Боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор насан туршийн суралцахуйн төвийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд үе | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаттайгаар шилжүүлж, гэрээ байгуулан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, дүүргийн Засаг даргад үүрэг болгосугай" гэсэн заалтыг хасаж, тогтоолыг төслийг "Насан туршийн суралцахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" гэснийг өөрчлөн "Журам батлах тухай" болгосон. Тогтоолын төсөл батлагдсанаар гадаад улсад амьдарч буй Монгол Улсын харьяат хүүхдүүд монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалаа суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, монгол хүний хөгжлийг дэмжих, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чухал | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | алхам болох юм. Хавсралт: 1 файл | | |
| 1.1.4 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн ажилтны ажил мэргэжлийн болон сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургуулийн Багшийн мэргэжлийн чадамжийн стандартын төсөл боловсруулна. | - | стандартын төсөл | - | Судалгаа хийгдэж, цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, захирлын ажил мэргэжлийн стандартын болон багшийн мэргэжлийн чадамжийн стандартын төсөл боловсруулса | - | Тайлант хугацаанд 2023 оны IV дүгээр улиралд эцэслэгдсэн цэцэрлэгийн багш, багшийн туслах, арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч, хоол зүйчийн стандартын төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлуулах бэлтгэлийг хангаж ажиллалаа. Тус зөвлөлөөс эдгээр стандартуудыг зарчмын хувьд дэмжсэн хэдий ч мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц батлагдсаны дараа батлахаар тогтсон болно. Мөн өмнө саруудад хийгдсэн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтны чиг үүргийг судалгаанд үндэслэн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн | 90% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын менежер, захирлын ажил мэргэжлийн стандартын төсөл боловсруулах ажлыг эхлүүлэх бэлтгэл хангаж байна. Багшийн мэргэжлийн чадамжийн стандартын төсөл боловсруулахтай холбоотойгоор олон улсын туршлага судалж, үйл ажиллагаандаа тусгаж ажилласан. Багшийн мэргэжлийн чадамжийн стандартын эхний хувилбар боловсруулагдсан. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, захирлын ажил мэргэжлийн стандартын боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд удирдах ажилтны чиг үүргийн судалгаа хийгдсэн. Удирдах ажилтны чиг үүргийн асуулгад ерөнхий боловсролын сургуулийн нийт | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | захирлын 82.9 хувь, цэцэрлэгийн эрхлэгчийн 89.2 хувь нь тус тус хамрагдлаа. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, захирлын ажил мэргэжлийн стандартын төсөл боловсруулах ажлыг эхлүүлсэн. Стандартын төслийг 2024 оны III улиралд багтаан Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн "17.5.Ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоод хамтран ажил мэргэжлийн стандартыг боловсруулна" гэж заасан. Энэхүү хуульд заасан байгууллагуудын ажлын ачаалллаас үүдэн ерөнхий боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургуулийн сургалтын менежер, захирлын ажил мэргэжлийн стандартын төсөл боловсруулах ажлыг төлөвлөсөн хугацаанаас хоцрогдолтой явж байгаа болно. | | |
| 1.2. | Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан байх | - | - | - | - | | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.7-д "Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт тавих шаардлага болон нэмэлт зардал, сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасны дагуу "Ерөнхий боловсролын сургуульд төрөлжсөн сургалт зохион байгуулах журам"-ын төсөл боловсруууллаа. Журмын төсөл нь ерөнхий боловсролын сургуулийн “Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалт”-ыг зохицуулж байсан журмыг Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нийцүүлэн зөвхөн “Төрөлжсөн” сургалт болгон шинэчилсэн онцлогтой. Тухайн чиглэлийн төрөлжсөн сургалтад хамрагдах нэг суралцагчид ногдох зардлыг Засгийн газрын “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 2024 оны 39 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүн”-ий “Нийт хувьсах зардал”-ын 30 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээтэй байхаар тусгасан. Сургалтын нэмэлт зардал нь зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсролын сургуульд хамаарахаар журамлав. Журмын төсөлд яамны холбогдох газар, хэлтэс, Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулиудаас тус тус санал авч судлан тусгалаа. Журмын төслийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Журам батлах тухай” 2024 оны А/262 дугаар тушаалаар батлууллаа. Журмын холбогдох материалыг бүрдүүлэн журмын хамт Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүллээ. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 6-р сарын 05-ны өдрийн 1/2884 албан бичгээр Захиргааны хэм | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6844 дугаарт бүртгэсэн. Хавсралт: 1 файл | | |
| 1.2.1 | Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхийн конвенцод нэгдэх хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ. | - | Хуулийн төсөл | Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 33 дугаар хуралдааны тэмдэглэл | Хуулийн төслийг Улсын их хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | - | Улсын Их Хурлын 2024 оны хаврын чуулганы 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах хууль батлагдсан. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хууль батлагдсанаар: - Монгол Улс дэлхийн улс орнуудтай дээд боловсролын салбарт хамтран ажиллах, бүс нутаг хоорондын инновацыг дэмжих; - дээд боловсролын салбар дахь олон улсын харилцан | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх; - Монголын дээд боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд хувь нэмрээ оруулах; - дээд боловсролын салбарт чанарын баталгаажуулалтын тогтолцоо, соёлыг төлөвшүүлж, чанарын баталгаажуулалтын найдвартай байдал, уялдаа холбоо, чадавхыг бэхжүүлэх боломж бүрдэж байна. Хавсралт: 4 файл | | |
| 1.2.2 | Ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам боловсруулж, батлуулна. | - | Ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам | - | Ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журмыг сайдын тушаалаар батлуулсан байна | - | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/182 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам”-ыг баталсан. Журам батлагдсанаар Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн, боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн холбогдох албан тушаалд ажилласан жилийг төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагад заасан хугацааг журмын хуульд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох эрх зүйн орчин бүрдэж байна. Хавсралт: 1 файл | | |
| 1.3. | Боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, боловсролын чанарын үнэлгээ болон насан туршдаа | - | - | - | - | | Улсын Их Хурлын 2024 оны хаврын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах хууль батлагдсан. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хууль батлагдсанаар - Монгол Улс дэлхийн улс орнуудтай дээд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын чиглэл боловсруулах | | | | | боловсролын салбарт хамтран ажиллах, бүс нутаг хоорондын инновацыг дэмжих, - дээд боловсролын салбар дахь олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, - Монголын дээд боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд хувь нэмрээ оруулахаас гадна - дээд боловсролын салбарт чанарын баталгаажуулалтын тогтолцоо, соёлыг төлөвшүүлж, чанарын баталгаажуулалтын найдвартай байдал, уялдаа холбоо, чадавхыг бэхжүүлэх боломж бүрдэж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанд “Гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг хэлэлцэж, 222 дугаар тогтоолоор баталсан. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох яамдаас санал авах явцад Сангийн яамны саналыг үндэслэн тогтоолын төслөөс "Боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор насан туршийн суралцахуйн төвийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд үе шаттайгаар шилжүүлж, гэрээ байгуулан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, дүүргийн Засаг даргад үүрэг болгосугай" гэсэн заалтыг хасаж, тогтоолыг төслийг "Насан туршийн суралцахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" гэснийг өөрчлөн "Журам батлах | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тухай" болгосон. Тогтоолын төсөл батлагдсанаар гадаад улсад амьдарч буй Монгол Улсын харьяат хүүхдүүд монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалаа суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, монгол хүний хөгжлийг дэмжих, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чухал алхам болох юм.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.3.1 | Насан туршийн суралцахуйн үзэл баримтлал батлуулна | - | Үзэл баримтлал | Судалгаа | Үзэл баримтлалыг боловсруулж, санал авч, хэлэлцүүлэн батлагдсан байна | - | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.12.1-д “Бүх насны иргэд насан туршдаа суралцах боломжийг дэмжих, тэдний бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах чиглэлээр насан туршийн боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгож өргөжүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд “Насан туршийн боловсролын үзэл баримтлал, үндсэн чиг үүргийг шинэчлэн боловсруулж, баталгаажуулсан байна.” гэж заасан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн “Насан туршийн суралцахуйн талаар баримтлах бодлогын чиглэл”-ийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/175 дугаар тушаалаар баталсан. Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ: 1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын насны | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүн амын боловсролд хамрагдалтад ахиц гарч; 2. Боловсрол, сургалтад хамрагдсан насанд хүрсэн иргэдийн эзлэх жин нэмэгдэн; 3. Эзэмшсэн мэдлэг, чадвар, чадамжаа хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулсан 25-аас дээш насны хүн амын эзлэх жин нэмэгдэж; 4. Насан туршийн суралцахуйн төвийн удирдлага, ажилтнуудын ажил мэргэжлийн стандарт, ажил үүргийн эрх зүйн орчин бүрдэж, төвийн үйл ажиллагаанд оролцсон орон нутгийн иргэдийн эзлэх жин нэмэгдэж; 5. Нэг иргэнд ногдох боловсрол, сургалтад зарцуулсан санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж; 6. Насан турштаа суралцахуйн удирдлага, мэдээллийн системтэй болж; | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 7.Монгол Улсын хүний хөгжлийн индексэд ахиц гарна. Төлөвлөсөн хугацаанд “Насан туршийн суралцахуйн талаар баримтлах бодлогын чиглэл”-ийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх ажил хийгдсэн. Бодлогын төсөлд ЮНЕСКО-гийн Насан туршийн боловсролын хүрээлэнгийн саналыг тусгасан<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.3.2 | Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ. | - | Үзэл баримтлалыг баталсан тогтоол | Судалгаа, хэлэлцүүлэг | Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарсан байна. | - | Боловсролын ерөнхий хуулийн 23.1, 23.4-д заасан Боловсролын үндэсний зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгуулсан анхдугаар хуралдаанаар "Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төсөл"-ийг хэлэлцэж, Засгийн газрын хуралдаанд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцүүлэх тэмдэглэл гарсан. Үзэл баримтлалын төслийг Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор баталлаа. Хавсралт: 1 файл | | |
| 1.3.3 | Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөөний төсөл боловсруулна. | - | Хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөө | Үзэл баримтлал | Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан байна. | - | Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах төлөвлөгөөний төсөл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулан яамны удирдлагуудад танилцуулж байна. Хавсралт: 4 файл | | |
| 1.3.4 | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний талаар баримтлах бодлогын чиглэл батлуулах, холбогдох журмыг шинэчилнэ | - | Бодлогын чиглэл | - | Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар бодлогын чиглэл баталсан байна | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний талаар баримтлах бодлогын чиглэл батлагдаж, холбогдох журмыг шинэчилсэн байна. | Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний талаар баримтлах чиглэлийг тусгуулан батлууллаа. Үүнд: "Суралцагчийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн тоглоом наадгай, сургалтын материал, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ, ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан сургалтын орчин бүрдүүлнэ, танхимын болон цахим сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног | 100% | 100 % |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төхөөрөмж, дэд бүтэц, сүлжээ, сургалтын системийн хүртээмжийг нэмэгдүүлнэ, багшлахуй, суралцахуйн үйл ажиллагаанд эрүүл, аюулгүй, харилцааны эерэг, тааламжтай орчин бүрдүүлнэ, сургалт, үйл ажиллагаанд ёс суртахууны хэм хэмжээг баримталж, суралцагчдын хувийн онцлог, ялгаатай хэрэгцээг хүлээн зөвшөөрч, тэгш, шударга хандана гэсэн чиглэл баримтална” хэмээн заасан. Мөн судлагдахуун бүрээр сурах бичиг (сурагчийн ном, багшийн ном, дасгал ажлын дэвтэр)-тэй байх ба хэвлэмэл болон цахим хэлбэрээр хэрэглэнэ, сурах бичиг нь агуулгын хувьд уламжлал, шинэчлэлийн зохистой харьцааг баримтална, боловсролын ерөнхий хуулийн | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 14.4-д заасан агуулгаас гадна эдийн засаг, санхүүгийн боловсрол, соёлын олон янз байдлын мэдлэг, чадвар, төлөвшил эзэмшүүлэхэд чиглэсэн агуулга, арга зүйн шийдэлтэй байна, дасгал, даалгавар нь танин мэдэхүйн дээд эрэмбийн сэтгэх чадварыг хөгжүүлэх, үнэлэхэд чиглэсэн, олон улсын үнэлгээний даалгаврын тавил, бүтцийн дагуу, үе шаттай гүйцэтгэх боломжтой байна, цахим сурах бичиг дэх тайлбар, дасгал, даалгаврыг суралцагч бие даан гүнзгийрүүлэн судлах боломжийг бүрдүүлэх, цахим сурах бичиг нь гар утас болон таблет ашиглан онлайн болон оффлайн горимд суралцагч бие даан судлах боломжтой байна" гэх мэт. Үзэл баримтлал дахь | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сурах бичгийн талаар баримтлах чиглэл батлагдсанаар түүний дагуу ЕББУЗГ сурах бичгийн журмын төсөл боловсруулах боломж бүрдсэн. Уг журмын төсөл дээр ЕББУЗГ-тай хамтран ажиллаж байна. Хавсралт: 1 файл | | |
| 1.3.5 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд боловсрол, шинжлэх ухааны асуудлаар тусгуулах санал боловсруулна. | - | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгах санал | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 12 асуудал тусгагдсан. | Төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж өгсөн байна. | - | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах чиглэлээр ЭЗХЯ-наас зохион байгуулсан "Үр дүнд суурилсан арга зүйгээр улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах нь" сургалтад хамрагдаж, сургалтаар өгсөн удирдамж, чиглэлийн дагуу улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг дараах үе шаттай боловсрууллаа. Үүнд: 1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/592 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг батлуулсан. 2. Яамны нэгж, харъяа байгууллагаас санал авч, нэггэн тусгасан. 3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд боловсрол, шинжлэх ухааны салбараас тусгуулах саналыг БШУЯ-ны 2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1а/168 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 4. ЭЗХЯ-наас зохион байгуулсан 2 удаагийн уулзалтад хуваарийн дагуу оролцож тодруулга, мэдээлэл өгч ажиллалаа. 5. Боловсрол, шинжлэх ухааны салбараас тусгуулах төсөл, арга хэмжээний талаар танилцуулга, тайлбар зэрэг мэдээллийг 2-5 саруудад тухай бүр өгч, хүргүүлж ажиллалаа. 6. Монгол Улсын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэхэд саналаа тухай бүр албан бичгээр хүргүүллээ. Хавсралт: 7 файл | | |
| 1.3.7 | Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргана. | 1.3 сая ам.дол | Системийн чадавх бэхжүүлэх төслөөр салбарын хүчин зүйлийн шинжилгээ хийж, тэргүүлэх чиглэлийн жагсаалт | Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ, Төслийн санал | Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, салбарын тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон байна. Хэрэгжүүлэгч байгууллага /Grant agency/-г сонгон, "Системийн чадавхийг бэхжүүлэх" буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргасан байна. | Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байна | Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргах хүрээнд дараах үе шаттай ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд хамрагдах хүрээнд Дэлхийн банкны олон улсын болон дотоодын зөвлөхүүд салбарын хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Салбарын хүчин зүйлийн шинжилгээний үр дүн, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажлын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэсгийн уулзалтыг зохион байгуулж, LEG-ийн техникийн хурлыг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулж, хэлэлцүүллээ. 2. Монгол Улсын боловсролыг дэмжих “Олон нийтийн бүлэг”-ийн /LEG/ хандивлагч улс, олон улсын байгууллагын удирдлагын дээд түвшний зөвшилцөх уулзалтыг 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдөр зохион байгууллаа. Дээд түвний зөвшилцөх уулзалтаар GPE-ийн “Системийн чадавхийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд боловсруулсан "Шинэчлэлийн тэргүүлэх чиглэл”, салбарын нөхцөл байдлын шинжилгээ /Enabling Factors Analysis/-ний үр дүнг хэлэлцэн, баталлаа. 3. Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайжруулах" буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх байгууллагыг сонгох, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар шинэчлэн байгууллаа. Тус ажлын хэсгээс "Буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх байгууллага /grant agent/-ыг сонгон шалгаруулах удирдамж"-ыг боловсруулж, Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын "Системийн чадавхыг сайжруулах төсөл" буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллагыг /Grant Agent/ сонгон шалгаруууллаа. Буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллага /Grant | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Agent/-аар ажиллах хүсэлтийг Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сан ирүүлж, ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээгээр Дэлхийн банк сонгогдож, “Боловсролын олон нийтийн бүлэг” /LEG/-ээр баталгаажууллаа. Хавсралт: 10 файл | | |
| 1.3.8 | Боловсролын донор болон хөгжлийн байгууллагын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангана. | - | Боловсролыг дэмжигч түншлэгчдийн хуралдаан | Боловсролыг дэмжигч түншлэгчдийн багийн ажлын удирдамж | Боловсролын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэлэлцүүлсэн байна. | Боловсролын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэлэлцүүлсэн байна. | Боловсролын донор болон хөгжлийн байгууллагын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Монгол Улсын боловсролыг дэмжих “Олон нийтийн бүлэг”-ийн /LEG/ хандивлагч улс, олон улсын байгууллагын техникийн болон удирдлагын дээд түвшний зөвшилцөх уулзалтыг зохион байгууллаа. Дээд түвшний зөвшилцөх уулзалтаар GPE-ийн “Системийн чадавхийг | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайжруулах төсөл”-ийн хүрээнд боловсруулсан "Шинэчлэлийн тэргүүлэх чиглэл”, салбарын нөхцөл байдлын шинжилгээ /Enabling Factors Analysis/-ний үр дүнг хэлэлцэн, баталлаа. 2. Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах” буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх байгууллагыг сонгох, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар шинэчлэн баталлаа. Тус ажлын хэсгээс "Буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх байгууллага /grant agent/-ыг сонгон шалгаруулах удирдамж"-ыг боловсруулж, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Системийн чадавхыг сайжруулах төсөл” буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллагыг /Grant Agent/ сонгон шалгаруууллаа. Буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллага /Grant Agent/-аар ажиллах хүсэлтийг Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сан ирүүлж, ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээгээр Дэлхийн банк сонгогдож, “Боловсролын олон нийтийн бүлэг” /LEG/-ээр Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах төсөл” буцалтгүй тусламж хэрэгжүүлэгч байгууллагыг /Grant Agent/ сонгон шалгаруулалтыг баталгаажууллаа. 3. Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй PISA нэмэлт шинжилгээг хийж гүйцэтгэх ажлын хэсгийн хурал, үйл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааг зохион байгууллаа. 4. Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр хэрэгжүүлэх төслийн дизайн боловсруулахад шаардлагатай холбогдох мэдээлэл судалгаагаар хангав. Хавсралт: 3 файл | | |
| 1.3.9 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих Боловсрол салбарт инновацыг дэмжих төслийн дизайн боловсруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | 3 сая ам.дол | Төслийн дизайн | - | Төслийн дизайн боловсруулахад дэмжлэг үзүүлсэн байна. | Азийн Хөгжлийн Банк төслийг баталсан байна. | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих Боловсрол салбарт инновацыг дэмжих төслийн дизайн боловсруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих Боловсролын салбарт инновацыг дэмжих төслийн дизайн боловсруулахад дэмжлэг үзүүлж, ажиллалаа. Тус төслийн үзэл баримтлал батлагдаж, төслийг хэрэгжүүлэгч сургалтын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагыг сонгох судалгаа хийх чиглэлээр АХБ-ны ахлах мэргэжилтэн Хёнжү Юн Монгол Улсад ажиллаж, 157, 159, Орчлон сургуулиудийн STEAM, байгалийн ухааны лаборатори, Мэдээллийн технологийн танхимтай танилцаж, төсөл хэрэгжүүлэх сургуулийн нөхцөл байдлыг судалж, холбогдох мэдээллийг цуглуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Хавсралт: 4 файл | | |
| 1.3.10 | Сургалтын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн дахин төлөвлөлт хийх зураглал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах | - | Бүтэц, зохион байгуулалтын талаар баримтлах чиглэл | - | Удирдамж | Сайдын тушаалаар батлагдсан байна. | Хугацаа болоогүй. Дэлхий дахинд баримталж буй ирээдүй хойч үедээ унаган байгалийг алдагдуулахгүй өвлүүлэх тогтвортой хөгжлийн үзэл санаа, орчин үеийн онолын чиг хандлага, хот, хөдөөгийн хөгжлийг тэнцвэржүүлэх практик хэрэгцээ шаардлагаас үүдэн "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн | 50% | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үзэл баримтлал"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны холбогдох ажлын хэсэгтэй нэгжийн дарга, ахлах шинжээчийн хамт 2 удаагийн уулзалтад оролцож, санал солилцсон. Шинэчлэн боловсруулсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг Эдийн засаг, хөгжлийн сайд 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хурлын даргад өргөн барилаа. Тус үзэл баримтлалд 6 бүлэг, 1 эрхэм зорилго, 7 зорилго, 197 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Монгол Улсыг эдийн засгийн "Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын" гэсэн долоон бүсчлэлийн тогтолцоогоор | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжүүлэхээр тодорхойллоо.. Үүнд: • Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг; • Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг; • Хойд бүсэд: Булган, Орхон, Хөвсгөл аймаг; • Төвийн бүсэд: Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг; • Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг; • Говийн бүсэд: Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг; • Улаанбаатарын бүсэд: Улаанбаатар ба дагуул хот. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал шинэчлэн батлагдсаны дараа үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. БШУСайдын 2024 оны 04 дүгээр сарын 29-ны "Санал хүргүүлэх тухай" 1а/1707 тоот албан | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичгээр ЭЗХСайдад "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д санал хүргүүлсэн байна. Хавсралт: 1 файл | | |
| 1.3.11 | Салбарын барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, насжилтыг уртасгах байдалд баримтлах зарчим, зааврыг боловсруулна | - | Заавар | - | Судалгаа хийгдсэн байна | Сайдын тушаалаар батлагдсан байна | Хугацаа болоогүй. Судалгааны ажил хийгдэж байна. Хавсралт: 3 файл | 50% | 50% |
| 1.3.12 | Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын бага ангийн сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх багц хэрэглэгдэхүүний төсөл боловсруулна | - | Сургалтын хөтөлбөр, түүний багцын төсөл | Үзэл баримтлал болон сургалтын хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөөний төсөл | Судалгаа хийгдсэн байна | Сургалтын хөтөлбөр, суралцагчийн сурах бичиг, дасгал ажлын дэвтэр, багшийн ном, гарын авлага, зөвлөмж | Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинэчлэн боловсруулах төлөвлөгөөний төсөл боловсруулан яамны удирдлагуудад танилцуулж байна. Тус төлөвлөгөө батлагдсанаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын 1-5 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг 2024 оны 6-8-р сард багтаан шинэчилж, сургалтын хөтөлбөрт нийцүүлэн суралцагчийн сурах бичиг, дасгал ажлын дэвтэр, багшийн ном, цахим сургалтын гарын авлагыг багцаар нь боловсруулна. Сургалтын хөтөлбөр болон багц хэрэглэгдэхүүнийг турших, тохирцыг шалгах ажлыг 2024-2025 оны хичээлийн жилд тодорхой тооны цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлнэ. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана. Хавсралт: 4 файл | | |
| 1.3.13 | Боловсролын сургалтын байгууллагын багшийн талаар баримтлах бодлогын чиглэл боловсруулна | - | Бодлогын чиглэл | Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын багшийн 2030 он хүртэлх хэрэгцээний судалгаа, багшийн талаар баримтлах бодлогын төсөл | Багшийн талаар баримтлах "Гурван тулгуурт" бодлогын чиглэл батлагдсан байна. | - | Тайлант хугацаанд ""Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээ"-г Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 192 дугаар тогтоолоор батлуулсан. ""Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээ"-д багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх болон багшийн чанарыг сайжруулах чиглэлээр тодорхой зорилтуудыг тусгалаа. Арга хэмжээ хэрэгжсэнээр | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дараах үр дүнд хүрнэ. Үүнд: 1. мэргэжлийн багшийн хангалт 100 хувьд хүрч; 2. багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын гарааны багшийн стандартын хангасан төгсөгчийн эзлэх хувь 70-аас доошгүй хувьтай болж; 3. багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 10-оос доошгүй хувиар нэмэгдэн байна; 4. багшийн нийгмийн баталгаа, цалин хөлсний талаар сэтгэл ханамжийн түвшинд жил бүр ахиц гарч; 5. сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг үнэлэх ажлын үр дүнд ахиц гарч; 6. багшийн цалин хөлсний дундаж хэмжээ нь улсын дундаж хэмжээнд хүрч; 7. нэг багшид ногдох | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцагчийн улсын дундаж 20-д хүрнэ. "“Багшийн гурван тулгуурт бодлого”-ын төслийг төлөвлөсөн хугацаанд боловсруулж, Монголын багш нарын VIII их хурлын шийдвэрийг тусган, бодлогын чиглэлийг Засгийн газарт хэлэлцүүлж батлуулсан. Хавсралт: 1 файл | | |
| 1.3.14 | Боловсролын салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох эрх зүйн баримт бичиг, шийдвэр, зохицуулалтын төсөл боловсруулна. | - | Судалгаа, тушаал, шийдвэрийн төсөл | - | Хийгдсэн судалгаа, тушаал, шийдвэрийн тоо | Хийгдсэн судалгаа, тушаал, шийдвэрийн тоо | 2024 оны эхний хагас жилд боловсролын салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох эрх зүйн баримт бичиг, шийдвэр, зохицуулалтын төсөл боловсруулж, батлууллаа. Тухайлбал: 1. Боловсрол, шинжлэх ухааны сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2024 онд орон нутагт Боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээ, Засаг дарга нарын 2024 онд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгуур, зорилтод түвшний матрицыг холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэлээ. 2. Ерөнхийлөгчийн ивээл дор 2024 оны 04 дүгээр сарын 11-12-нд зохион байгуулагдсан Монголын багш нарын VIII дугаар их хурлын үеэр хийгдсэн "Багшийн 3 тулгуурт бодлого" илтгэлийн мэдээлэл, их хурлын баримт бичиг /Concept Note/-ыг боловсруулах, их хурлын нэгдсэн болон салбар хуралдаан, Панелист болон нээлттэй хэлэлцүүлгийн асуулгын чиглэл, зохион байгуулалт, их хурлын шийдвэрүүдийн төсөл зэргийг боловсруулан бэлтгэж, шийдвэрийн төслийг боловсруулахад оролцож, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн хэлэх үгийн төсөл, VII их хурлын шийдвэрийн хэрэгжилтийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулгыг бэлэн болгосон. 3. Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн "Олон улсын PISA 2022 үнэлгээний Монгол Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 105 дугаар тогтоолыг батлуулсан 4. Судалгаа хийгдэж, БШУ-ны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны А137 дугаар тушаалаар аймаг, нийслэлийн БШУГ, НДБХ-ийн бүтэц орон тоог батлуулсан 5. Боловсролын үндэсний зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн анхдугаар хуралдааныг зохион байгуулж, "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал", "Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын "PISA-2022" үнэлгээний Монгол Улсын үр дүн, цаашид авах арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцүүлж, тэмдэглэлд заасны дагуу дэмжсэн. 6. БШУ-ы сайдын “Журам батлах тухай” 2024 оны А/262 дугаар тушаалаар "Төрөлжсөн сургалт зохион байгуулах журам" батлуулж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэв. Хавсралт: 8 файл | | |
| 1.3.15 | Багшийн хөгжлийн үндэсний болон орон нутагт дахь бүсийн төвийг байгуулах | - | сайдын тушаал | - | Багшийн хөгжлийн үндэсний болон орон нутагт дахь бүсийн төвийг байгуулах шийдвэр гарсан байна. | - | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар "Багшийн хөгжлийг дэмжих төвийн жишиг бүтэц, орон тоо"-г баталсан. Тушаал батлагдсанаар Монгол Улсын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Боловсролын их сургуулийг түшиглэн Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Архангай аймаг дахь Багшийн сургууль, Монгол Улсын Их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, Монгол Улсын Их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургуулийг тус тус түшиглэн Багшийн хөгжлийг дэмжих бүсийг төв байгуулах эрх зүйн орчин бүрдлээ. Тушаал гарсантай холбоотойгоор Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийн нээлтийн үйл ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Багшийн хөгжлийн үндэсний болон орон нутагт дахь бүсийн төвийг байгуулах шийдвэрийн төсөл able системд төлөвлөгдсөн хугацаанд батлахаар орсон, удирдлагаас | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өгсөн чиглэлийн дагуу хүлээгдсэн. Хавсралт: 2 файл | | |
| 1.4. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ | - | - | - | - | | Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь Авилгатай тэмцэх газартай хамтран "Ёс суртахууны хариуцлага" хэмээх сургалтыг дэмжих туршилтын сургалтын хөтөлбөр боловсруулж 2023-2024 оны хичээлийн жилийн 3-4 дүгээр улиралд нийслэлийн 8, аймаг, сумын 8 нийт 16 сургуулийн 10 дугаар ангийн нийт 480 орчим суралцагчийг тус хөтөлбөрт хамруулж байна. АТГ-ын холбогдох удирдлага, мэргэжилтнүүдтэй туршилтын үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар 3 удаа уулзаж санал солилцлоо. БСҮХ-ээс туршилтын үр дүнг нэгтгэн дүгнэсэн. Туршилтын үр дүнд тулгуурлан тус хөтөлбөрийг цаашид | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ерөнхий боловсролын сургуульд хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Туршилтын сургалтын хөтөлбөрийг Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д нийцүүлэн ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. | | |
| 1.4.1 | Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг тусган | - | Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг | - | Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг | Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг тусгасан байна. | Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь Авилгатай тэмцэх газартай хамтран "Ёс суртахууны хариуцлага" хэмээх сургалтыг дэмжих туршилтын сургалтын хөтөлбөр | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллана. | | тусгасан байна. | | тусгасан байна | | боловсруулж, 2023-2024 оны хичээлийн жилийн 3-4 дүгээр улиралд нийслэлийн 8, аймаг, сумын 8, нийт 16 сургуулийн 10 дугаар ангийн 480 орчим суралцагчийг тус хөтөлбөрт хамруулж байна. АТГ-ын холбогдох удирдлага, мэргэжилтнүүдтэй туршилтын үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар 3 удаа уулзаж санал солилцлоо. БСҮХ-ээс туршилтын үр дүнг нэгтгэн дүгнэсэн. Туршилтын үр дүнд тулгуурлан тус хөтөлбөрийг цаашид ерөнхий боловсролын сургуульд хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ. | | |

*Үнэлсэн:* .........................

*..........................................* ......................... */................................./*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*

*Тайлагнасан:* *.........................*

*..........................................* *.........................* */................................./*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*